



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

УИХ-ын саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлан



**ТҮРЭЭСИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТООЦОЖ,
ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА**

Улаанбаатар хот
2007 оны 6 дугаар сар

Агуулга

Тайланг бэлтгэсэн:		
ҮАГ-ын хоёрдугаар газар	Товчилсон үгсийн жагсаалт	3
<i>Захирал</i>		
<i>О.Мэндбаяр</i>		
<i>Аудитын менежер</i>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
<i>Х.Баярмаа</i>		
<i>Ахлах аудитор</i>	Бүлэг 1 “Цахим Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин шаардлагатай байна	
<i>С.Сэрчхорол</i>		
<i>Аудитор</i>		
<i>Д.Норовсамбуу</i>		
<i>Ж.Ядмаа</i>		
<i>Шинжээч</i>		
<i>Р.Цолмон</i>		
2007 оны 6 дугаар сар	<hr/>	
	<ul style="list-style-type: none">• Мэдээлэл, харилцаа холбооны багц хуулиуд батлагдаагүй байна	5
	<ul style="list-style-type: none">• “Бүх нийтийг компьютержуулах” хөтөлбөрийн үйл ажиллагаа суларч байна	8
Уг тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:	<ul style="list-style-type: none">• Зөвлөмж	9
<u>www.mnao.pmis.gov.mn</u>		
<i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533, 263577 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	Бүлэг 2 Түрээсийн орлогыг бүрэн тооцож, төвлөрүүлээгүй байна	
ХАЯГ:	<ul style="list-style-type: none">• Түрээсийн орлогыг зөв тооцохгүй байна	11
<i>Үндэсний аудитын газар</i>	<ul style="list-style-type: none">• МХХТГ үндсэн хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаагүй байна	13
<i>Засгийн газрын 4 дүгээр байр,</i>	<ul style="list-style-type: none">• Зээл, зээлийн хүүгийн төлбөрийг улсын төсвөөс төлжээ	14
<i>Бага тойруу-6, Улаанбаатар-46</i>		
<i>Монгол Улс</i>		

Агуулга

- Зөвлөмж 14
- Холбогдох байгууллагын санал 15

Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
МХХТГ	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбоо, технологи
МХХ	Мэдээлэл, харилцаа холбоо
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
МТЗ	Монголын төмөр зам
МКНХ	Монголын компьютер нийлүүлэгчдийн холбоо
МХХХТ	Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төв
АХБ	Азийн хөгжлийн банк
ТӨХ	Төрийн өмчийн хороо
МЦХХК	Монголын цахилгаан холбоо ХК
УХСХ	Улс хоорондын сүлжээний хөрөнгө
ОНБХХСХ	Орон нутгийн болон хот хоорондын сүлжээний хөрөнгө
СЭЗС	Санхүү, эдийн засгийн сайд (хуучин нэрээр)

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны хүсэлт, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Энэхүү аудитын зорилт нь Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын 2004-2006 оны үйл ажиллагааны үр дүнг дараахь чиглэлээр шалгаж, дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж өгөхөд чиглэгдэв. Үүнд:

- Цахим Монгол хөтөлбөрийн 2005, 2006 оны хэрэгжилт, үр дүн
- Санхүүгийн үйл ажиллагааны үр нөлөөт байдал

Аудитад гүйцэтгэлийн аудитын дор дурдсан арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагаатай танилцаж, холбогдох ажилтнуудаас судалгаа, тодруулга авах
- Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төв (хуучин)-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр дүнг шалгах
- Цахилгаан холбооны үндсэн сүлжээний хөрөнгийн түрээсийн орлого төвлөрүүлэлтийн байдалд дүн шинжилгээ хийх
- Дамжуулан зээлдүүлэх гэрээний үүргийн биелэлт, төлөлт, хүүгийн тооцооллыг шалгах
- Ажлын гүйцэтгэлийн тайлантай танилцах, шаардлагатай үед холбогдох бусад байгууллагаас тодруулга авах

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад Сангийн яам, МХХТГ болон түүний харъяа МХХХТөв болон бусад холбогдох байгууллагууд хамрагдлаа.

Бүлэг 1

"ЦАХИМ МОНГОЛ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ШААРДЛАГАТАЙ БАЙНА



1.1 УИХ-ын 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрыг байгуулжээ.

1.2 МХХТГ нь Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдаас мэдээлэл харилцаа холбоо, технологийн асуудлаар баримтлах бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын эрх зүйн орчинг бүрдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилт, салбарын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, удирдлага зохицуулалтаар хангах үндсэн чиг үүрэгтэй.



1.3 Монгол Улсын Засгийн газар "Цахим Монгол" үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. "Цахим Монгол" хөтөлбөр нь мэдээлэл, харилцаа холбоо, технологийг 21 дүгээр зууны хөгжлийн үндсэн хурдасгуур гэж үзэж, эдийн засгийн шинэ орчин, оюунлаг чадавхийг бий болгох, улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангах замаар хүн амын амьдралын чанарыг сайжруулж, 2012 он гэхэд мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн гол үзүүлэлтүүдээр Ази тивдээ эхний 10 улсын тоонд орох үндсэн зорилготой юм.

1.4 Дээрх зорилгын хүрээнд 2005-2006 онд дараахь зорилтуудыг дэвшүүлжээ. Үүнд:

- ✚ МХХТ-ийг нэвтрүүлэх, хөгжүүлэх эрх зүйн орчин бий болгох
- ✚ Улс орныг хамарсан өндөр хурдны нэгдсэн сүлжээ байгуулах
- ✚ Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх
- ✚ Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бий болгох
- ✚ Бүх нийтийг компьютержуулах

Мэдээлэл, харилцаа холбооны багц хуулиуд батлагдаагүй байна

1.5 Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр Засгийн газраас 5 хуулийн төсөл санаачлан

УИХ-д өргөн барьснаас 2005-2006 онд 3 хуульд шинээр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

1.6 МХХТГ одоогийн мөрдөж байгаа “Харилцаа холбооны тухай” хуулийг шинэчлэн “Мэдээлэл харилцаа, холбооны тухай” хуулийн төсөл болгон шинэчлэн боовсруулсны зэрэгцээ мэдээлэл харилцаа холбооны багц хуулийн төслийг 2006 онд боловсруулж Засгийн газарт хүргүүлээд байна. Үүнд тухайлбал, Мэдээлэл, харилцаа холбооны тухай хуулийн төсөл, Цахим засаглалын тухай хуулийн төсөл, Цахим хэлцлийн тухай хууль буюу Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүд багтаж байна.

1.7 Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн орчин бүрдээгүй нь “Цахим Монгол” хөтөлбөрийн цахим арилжаа хийх, цахим мэдээлэл солилцох, санхүүгийн гүйлгээ хийх, мэдээлэл солилцооны аюулгүй байдал зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгож чадахгүй байна.

1.8 Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд дотоодын програм хангамжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээс худалдан авсан бараа, импортоор нийлүүлж байгаа компьютер, принтер, скайнер, тэдгээрийн эд ангиудыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийг 2005 оноос 4 жил мөрдөхөөр батлуулсан боловч татварын багц хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор энэ оны 1 дүгээр сарын 1-ээс хүчингүй болсон байна.



1.9 “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах талаар дараахь төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлжээ. Үүнд:


№	Чиглэл	Шилэн кабелийн урт /км/	Хэрэгжүүлсэн он	Хөрөнгийн эх үүсвэр
1	Улаанбаатар-Дашинчилэн-Булган	400	2004-2005	Дотоодын хөрөнгө оруулалт
2	Чойр-Улаанбаатар-Дархан-Эрдэнэт	700	2005-2006	Дотоодын хөрөнгө оруулалт
3	Улаанбаатар хот	100	2004-2005	Дотоодын хөрөнгө оруулалт
4	Баруун болон баруун хойд	1598	2005-2006	Улсын нэгдсэн төсөв болон дотоодын хөрөнгө оруулалт
5	Арвайхээр-Даланзадгад-Мандалговь	700	2005-2006	Улсын нэгдсэн төсөв болон дотоодын хөрөнгө оруулалт

1.10 Дээрх төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний үр дүнд 21 аймгийн төв, 88 орчим сум, суурин газрыг хамарсан өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ тавигдаж, шилэн кабелийн сүлжээний нийт урт 7300 км болж, “Цахим Монгол”

хөтөлбөрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх зорилт хэрэгжих нөхцөл бүрджээ.

1.11 "Цахим Монгол" хөтөлбөрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн нэг зорилт бол суурин телефон, утасгүй суурин холбоо, үүрэн холбоог хөгжүүлэх явдал юм.

1.12 МХХ-ны салбар дахь чөлөөт өрсөлдөөнийг гүнзгийрүүлэх, үүрэн телефоны үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлчилгээний үнэ тарифыг бууруулах, интернэт хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор үүрэн телефон



үйлчилгээний операторын тендерийг 2 удаа шалгаруулж, үүрэн телефоны операторын тоог нэмэгдүүлсний үр дүнд үүрэн телефон үйлчилгээний үнэ тариф дунджаар 20-30 хувь хямдрах боломжийг бүрдүүлжээ.

1.13 Ингэснээр 100 хүнд ногдох үүрэн телефон хэрэглэгчийн нягтрал 2005 онд 22,4 % байсан бол 2006 онд 32,08%-д хүрч суурин холбооны нягтралаас даруй 5 дахин их болсон байна.



1.14 2005-2006 онд хэрэгжүүлсэн "Төрийн ордны утасгүй сүлжээ" төслийг Германы Сэргээн босголтын банкнаас санхүүжсэн "Харилцаа холбоо-2", "Харилцаа холбоо-3" төслийн үлдэгдэл 209,0 мянган евро, МХХТ-ийн 32,2 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

1.15 Энэ төслийн хүрээнд Төрийн ордонд утасгүй сүлжээний тоног төхөөрөмж суурилуулж, УИХ-ын Тамгын газрын мэдээллийн сүлжээний сервер, сүлжээний холболтын төхөөрөмжийг шинэчилж, УИХ-ын гишүүн бүрт нэг бүр нь 1,898.4 мянган төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер олгосон байна.

1.16 "Төрийн ордны утасгүй сүлжээ" төслийн хүрээнд шаардагдах техник, тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн хороо, үнэлгээний хэсгийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 34 дүгээр тушаалаар байгуулж, тендерт оролцсон 8 компаниас "Скай Си энд Си" ХХК-г сонгон шалгаруулж гэрээ байгуулсан бөгөөд тус компани 2007 оны 2 дугаар сарын 15-ны өдөр 309,095.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Төрийн холбооны газарт хүлээлгэн өгчээ.



**"Бүх нийтийг компьютержуулах"
хөтөлбөрийн үйл ажиллагаа
суларч байна**

1.17 Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Эрчим хүчний байнгын эх үүсвэртэй, хүн ам төвлөрсөн газрын сургууль, айл өрхийг компьютержуулж, интернэтийн үйлчилгээ, хүртээмжийг өргөжүүлнэ" гэсэн зорилт болон "Цахим Монгол" үндэсний хөтөлбөрийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд МХХТГ-аас салбарын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хамруулан "Бүх нийтийг компьютержуулах" хөтөлбөрийг 2005 оны 6 дугаар сард эхлүүлжээ.

1.18 "Бүх нийтийг компьютержуулах" хөтөлбөрийг дэмжиж, компьютерийн худалдаа, үйлчилгээний компаниуд (Онлайн төв, М-Си-Эс Электроникс, Сайн компьютерс, БСБ сервис, Номин Электроникс, Мигма Электроникс, Цахим системс, Саммит технологи, Нью Соник, Бодь Электроникс, МТ Электроникс, Бит сервис, БитТНН зэрэг) нэгдэж, компьютер нийлүүлэгчдийн холбоог 2005 оны 6 дугаар сард байгуулжээ.

1.19 Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат 2005-2006 онд хэрэгжсэн бөгөөд компьютерийн үзэсгэлэн худалдааг МКНХ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран 11 удаа зохион байгуулж 110 гаруй мянган компьютер борлуулж, 1000 хүнд ногдох компьютерийн тоог 2006 онд 2004 оныхоос 4,8 дахин нэмэгдүүлжээ. Түүнчлэн ХААН, ХАС банкууд идэвхтэй оролцож иргэдэд компьютерийг урьдчилгаагүй зээлээр олгодог болсон нь хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой ажил болж байна.

1.20 НӨАТ-ын хуульд оруулсан дээрх өөрчлөлт нь хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгжүүд төдийгүй нийт компьютерийн худалдаа, үйлчилгээний бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, тэднийг хөтөлбөрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах гол хөшүүрэг болж байсан бол хуулийн уг нэмэлт өөрчлөлт хүчингүй болсон нь хөтөлбөрийн үйл ажиллагааг сааруулах хандлагатай байна.



1.21 МХХТГ нь "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд "Өрх бүрт интернэт" аяныг 2006 оны 5 дугаар сараас эхлүүлсэн бөгөөд өндөр хурдны интернэтийн үйлчилгээг Мэйжикнэт, Миком, М-Си-Эс ком, Скай Си энд Си, Вайрлесском, Рейлком, Мобинет зэрэг компаниуд, утасгүй холбооны технологийн холболтын үйлчилгээг "Улуснэт" ХХК-тай хамтран хэрэгжүүлж байна.

1.22 Ингэснээр интернэтийн үнэ хямдрах, хэрэглэгчдийн тоо нэмэгдэх, цагийн хязгаарлалтгүй интернэт ашиглах зэрэг нөхцөл бүрджээ. Тухайлбал, интернэтийн сарын хэрэглээний үнэ 60-120 ам.доллар байсан бол буурч 2006 оны 5 дугаар сараас 19.99 ам.доллар болжээ.

1.23 Интернетийн олон улсын гарцын үнэ 2004 оны 3 дугаар сард 3250 ам. доллар байсныг 2005 оноос 400 ам. доллар болгон бууруулснаар интернэт хэрэглэгчдийн тоо даруй 3 дахин өсөж 300000 гаруй болсон байна.

Зөвлөмж :

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд, МХХТГ-ын дарга Ч.Сайханбилэг нарт:

- Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгоход чиглэгдсэн багц хуулиудын төслийг зохих журмын дагуу хэлэлцүүлж УИХ-д өргөн мэдүүлэх;
- “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр болон түүний хүрээнд хэрэгжүүлж эхэлсэн дэд хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авах;

Бүлэг 2

ТҮРЭЭСИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТООЦОЖ, ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

2.1 Холбооны хөрөнгийн компани 1995 оноос ажилласан бөгөөд Засгийн газрын 1996 оны 300 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шуудан цахилгаан холбооны газар, Засгийн газрын 2004 оны 207 дугаар тогтоолоор Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын харъяанд Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төв байгуулагдсан байна.

2.2 МХХХТ нь МУ-ын цахилгаан холбооны техник, технологийн бүтэц зохион байгуулалт, улс орны зах зээлийн багтаамж, хэрэглээний онцлогтой уялдсан тооцоо судалгаа боловсруулан, үндсэн сүлжээний тогтвортой үйл ажиллагааг хангах, өргөтгөх, шинэчлэн хөгжүүлэх төслийг улсын хэмжээнд харилцан уялдаатай хөгжүүлэх үндсэн зорилготой, цахилгаан холбооны төрийн өмчийн үндсэн сүлжээ эзэмшигч юм.

2.3 Засгийн газрын 2006 оны 186 дугаар тогтоолыг үндэслэн ТӨХ-ны 2006 оны 491 дүгээр тогтоолоор МХХХТ-д Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын техникийн төв (хуучин нэрээр)-өөс шилжүүлсэн зарим үндсэн болон эргэлтийн хөрөнгө, “Монголын цахилгаан холбоо” ХК (МЦХХК)-ийн түрээсээр ашиглаж байгаа монополь шинжтэй суурь болон салбар сүлжээний кабель шугам, тоног төхөөрөмж, барилга байгууламжийг түшиглэн зөвхөн сүлжээний үйлчилгээ явуулах “Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулжээ.

2.4 Монголын холбооны хөрөнгийн компани (хуучин нэрээр), “Монголын цахилгаан холбоо” ХК 1995 оны 8 дугаар сарын 31-ний өдөр түрээсийн гэрээ байгуулжээ. Уг гэрээнд МЦХХК нь орон нутаг, улс, хот хоорондын цахилгаан холбооны тодорхой хөрөнгийг (сүлжээний тоног төхөөрөмж, байгууламж, орон барилга ба өмчийг хязгаарлалтгүйгээр оролцуулан) түрээсээр авч 20 жил ашиглахаар заажээ.

2.5 Улс хоорондын сүлжээний хөрөнгө (УХСХ) нь түрээслэгчийн хэрэглэгч, бусад орнуудын цахилгаан холбооны хэрэглэгчийн хооронд телефон үйлчилгээ явуулдаг хөрөнгө байна. Орон нутгийн болон хот хоорондын сүлжээний хөрөнгө (ОНБХХСХ) нь дотоодын нийтлэг нутаг дэвсгэр буюу МЦХХК-ны хэрэглэгчийн хооронд телефон үйлчилгээ явуулдаг хөрөнгө байна.

2.6 Түрээсийн жилийн төлбөр нь УХСХ-ийн түрээсийн төлбөр дээр ОНБХХСХ-ийн түрээсийн төлбөрийг нэмсэнтэй тэнцүү байна.

2.7 Гэрээний дагуу УХСХ-нөөс 12.45 хувь, ОНБХХСХ-нөөс 7.45 хувиар тус тус түрээсийн төлбөр тооцон авдаг байна. Түрээсийн төлбөрийн бүтцийг авч үзвэл:

- УХСХ-ийн түрээсийн төлбөрийг УХСХ-ийн элэгдэл (4%) дээр УХСХ-ийн эргэн төлөгдөх хувь (5%), захиргааны зардал (0.20%), зээлийн хүү (3.25%)-г нэмж тодорхойлно.

- ОНБХХСХ-ийн түрээсийн төлбөрийг ОНБХХСХ-ийн элэгдэл (4%) дээр захиргааны зардал (0.20%), зээлийн хүү (3.25%)-г нэмж тодорхойлно.

Түрээсийн орлогыг зөв тооцохгүй байна

2.8 2006 оны эцсийн байдлаар МХХХТ-ийн МЦХХК-нд түрээслүүлж байгаа 106,163.0 сая төгрөгийн түрээсийн хөрөнгийн 7,370.4 сая төгрөгийг УХСХ, 98,792.7 сая төгрөгийг ОНБХХСХ тус тус эзэлж байна.

2.9 Түрээсийн жилийн төлбөрийн хэмжээг тодорхойлох томъёог 2000 оны 4 дүгээр сараас эхлэн 5 жил тутам эргэн хянахаар түрээсийн гэрээнд заасан боловч хөрөнгө эзэмшигч, түрээслэгч талууд түрээсийн төлбөрийн томъёоны хувийг өөрчлөх талаар одоог хүртэл тохиролцож чадаагүйн улмаас хөрөнгө эзэмшигчийн зардлыг бүрэн нөхөж чадахгүй байна. Түрээсийн томъёог өөрчлөх шалтгаан нь:


- ✚ Хөрөнгийн ашиглалтын жил, технологийн хөгжил, хүн ам зүйн өөрчлөлт зэргээс хамаарах элэгдэл хорогдлын хувийг өөрчлөх
- ✚ Захиргааны зардлын хэмжээг хөрөнгө эзэмшигчээс тодорхойлсон түвшинд боломжийн хэрээр ойртуулах үүднээс өөрчлөх
- ✚ Санхүүжилтийн зардал буюу зээлийн хүүгийн хэмжээг хөрөнгө эзэмшигчээс тодорхойлсон хэмжээнд дөхүүлэн хянах ба улс хоорондын болон орон нутгийн ба хот хоорондын сүлжээний хөрөнгөд хамааруулан зээлийн хүүг тооцохдоо хөрөнгө эзэмшигчийн зээлсэн болон зээлдүүлсэн бүх пассивын үзүүлэлтийг оролцуулах зэрэг болно.

2.10 МХХХТ 2004 онд СЭЗС (хуучин нэрээр)-ын 2004 оны 41 дүгээр тушаалын дагуу МЦХХК-ний түрээсийн орлогын 1,500.0 сая төгрөгийн 74.32 хувь буюу 1,114.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 25.68 хувь буюу 385.2 сая төгрөгийг Шуудан, цахилгаан холбооны газар (хуучин нэрээр)-ын урсгал зардал болон холбооны салбарын их засвар, хөрөнгө оруулалтад зарцуулжээ.


2.11 МХХХТ Сангийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалын дагуу МЦХХК-иас 2005 онд төвлөрүүлсэн 12,250.0 сая төгрөгийн түрээсийн орлогын 24.0 хувь буюу 2,942.4 сая төгрөгийг МХХХТ-ийн урсгал болон их засвар, хөрөнгө оруулалтад, 76.0 хувь буюу 9,307.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

2.12 Сангийн сайдын 2006 оны 79 дүгээр тушаалын дагуу МЦХХК-иас 2006 онд төвлөрүүлсэн 10,364.5 сая төгрөгийн түрээсийн орлогын 42.5 хувь буюу 4,409.9 сая төгрөгийг улсын төсөвт, 57.5 хувь буюу 5,954.6 сая төгрөгийг МХХХТ-ийн урсгал зардал, хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Түрээсийн орлогын төвлөрүүлэлт



Түрээсийн орлогын хуваарилалт



2.13 МЦХХК-ний түрээсээр ашиглаж байгаа хөрөнгө 2006 оны эцсийн байдлаар 106,163.0 сая төгрөг байгаагаас 2005-2006 онд хөрөнгө оруулалтаар 3,041.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, ТӨХ-ны 2006 оны 491,621 дугаар тогтоолоор 2,563.8 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Ингэснээр хөрөнгийн түрээсийн төлбөрт 2004-2006 онд 24,130.9 сая төгрөг төлөх ёстойгоос 22,614.5 сая төгрөгийг төвлөрүүлж 2006 оны эцсийн байдлаар 1,516.4 сая төгрөгийн түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Иймд дээрх хөрөнгийг нөхөн төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

2.14 Түрээсийн гэрээний дагуу түрээсийн төлбөрийн хэмжээг 1996 оны 4 дүгээр сараас эхлэн жил бүр эргэн хянах бөгөөд түрээсийн жилийн төлбөрийг түрээслэгч хөрөнгө эзэмшигчээс тогтоосон хэмжээгээр төлөх, энэхүү зүйлийн дагуу талууд түрээсийн төлбөрт цаашдаа явцын дунд өөрчлөлт оруулж болно гэж заажээ. Гэтэл хөрөнгө эзэмшигч, түрээслэгч тал 2004 оны эцэст МЦХХК-ий төлөх түрээсийн төлбөрийн тооцоог 1,691.3 сая төгрөгөөр, хөрөнгийн тооцоог 2004 оны 11 дүгээр сарын 1-ны байдлаар 105,685.4 сая төгрөгөөр баталгаажуулснаас өөр түрээсийн төлбөрийн тооцоо нийлсэн акт алга байна. Энэ нь үндсэн сүлжээнд технологийн шинэчлэл хийж, аналог системийн дамжуулах байгууламжийг тоон технологийн горимд шилжүүлснээр хуучин ашиглагдаж байсан хөрөнгийн түрээсийн төлбөрийн хэмжээг харилцан тохиролцож чадаагүйгээс болжээ.

2.15 ТӨХ-ны 2006 оны 671 дугаар тогтоолоор 2006 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад даалгасан байна. Үүнд:


- “Мэдээлэл, холбооны сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлсэн сүлжээний зориулалттай тоног төхөөрөмж болон барилга байгууламжийг үйлчилгээний компаниудад давхар түрээслүүлж байгаа гэрээг тасалбар болгон цуцлахыг “Монголын цахилгаан холбоо” ХК-ны захирал (О.Шаалуу)-д,
- Үйлчилгээний компаниудад ашиглуулах техникийн нөхцөл олгох, хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах, ашиглалт үйлчилгээний гэрээ хийх зөвшөөрлийг олгох зохицуулалтыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг

“Мэдээлэл, холбооны сүлжээ” ХХК-ны захирал (Ч.Нарантунгалаг)-д тус тус үүрэг болгожээ.

Өөрөөр хэлбэл, сүлжээний ашиглалт болон үйлчилгээний бизнесийг зааглаж, түүнтэй уялдуулан бүтэц зохион байгуулалтаа өөрчилж эхлээд байгаа боловч хөрөнгийн асуудал одоог хүртэл шийдэгдэлгүй иржээ. Энэ нь МУ-ын Засгийн газар, БНСУ-ын “Кореа Телеком” компанийн хооронд 1995 онд байгуулагдсан 20 жилийн хугацаатай түрээсийн гэрээний хугацаа дуусаагүйн улмаас МЦХХК хөрөнгөө бүрэн шилжүүлээгүйтэй холбоотой байна.

МХХТГ үндсэн хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаагүй байна

2004-2006 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл



2.16 МХХТГ-өөс гүйцэтгэх хөрөнгө оруулалтыг Сангийн сайдын тушаалаар 2004 онд 2616,2 сая төгрөг, 2005 онд 2366,3 сая төгрөг, 2006 онд 7041,0 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 2004 онд 1,647.3 сая төгрөг, 2005 онд 1,715.4 сая төгрөг, 2006 онд 7,143.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгджээ.

2.17 2004-2005 онд хөрөнгө оруулалт 968,8-650,9 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь он дамжиж зарим ажлыг гүйцэтгэсэн, тендерийг шалгаруулахад доод үнийг сонгосон, 2006 онд хөрөнгө оруулалт 102,5 сая төгрөгөөр хэтэрсэн нь Дундговь аймгийн шилэн кабелийн сүлжээний хөрөнгө оруулалт төлөвлөгөөнд тусгагдалгүй Засгийн газрын тогтоолоор шууд олгогдсонтой холбоотой байна.

2.18 МХХТГ 2004 оны 11 дүгээр сард байгуулагдахдаа 19.1 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж шууд худалдан авч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг зөрчсөн байна.

2.19 Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн зарим үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна. Тухайлбал, “Вэб, имэйл” төслийн хүрээнд бэлтгэсэн 121,241.6 мянган төгрөгийн үнэтэй төрийн байгууллагуудын вэб болон имэйл сервер тоног төхөөрөмж, Төрийн ордны утасгүй сүлжээ төслийн хөрөнгөөр бэлтгэсэн 4 ширхэг буюу 7,593.7 мянган төгрөгийн зөөврийн компьютер зэргийг данс бүртгэлд бүртгээгүй, КОИСА-ийн хамтын ажиллагааны хүрээнд хүлээн авсан 6 ширхэг зөөврийн компьютер, 1 ширхэг дижитал камер, сканнер, өнгөт, лазер принтерүүд, компьютер болон дагалдах эд анги, принтерийн хор зэргийг зах зээлийн үнээр үнэлж бүртгээгүй, суудлын автомашиныг 9,500.0 мянган төгрөгөөр дутуу үнэлсэн зэргийг залруулах нь зүйтэй гэж үзлээ.



Зээл, зээлийн хүүгийн төлбөрийг улсын төсвөөс төлжээ

- 2.20 Холбооны салбарыг хөгжүүлэх, холбооны суурь сүлжээг өргөтгөх, шинэчлэх болон салбарын удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох зорилгоор 1994 оноос хэрэгжүүлж эхэлсэн МОН-1300 багц төслийг АХБ, Германы Сэргээн босголтын банк зэрэг гадаадын санхүүжүүлэгч байгууллагуудаас Монгол Улсын Засгийн газарт олгосон хөнгөлөлттэй зээл, тусламжаар санхүүжүүлж байна.
- 2.21 1999-2006 онуудад МХХХТ-өөс зээл, зээлийн хүүгийн төлбөрт СЯ-д 37,658.0 сая төгрөг төвлөрүүлж, 2006 оны эцсийн байдлаар АХБ-аас авсан үндсэн зээлийн үлдэгдэл 30,715.1 сая төгрөг, Герман Улсын банкнаас авсан үндсэн зээлийн үлдэгдэл 20,970.6 сая төгрөг, Солонгос Улсын Экспорт импорт банкнаас авсан үндсэн зээлийн үлдэгдэл 12,345.7 сая төгрөг, Япон Улсын Засгийн газраас авсан үндсэн зээлийн үлдэгдэл 1,465.3 сая төгрөг, бүгд 65,496.8 сая төгрөгийн үндсэн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.
- 2.22 Сангийн сайдын 2006 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 79 дүгээр тушаалаар МХХХТ-ийн түрээсийн орлогод 4,754.9 сая төгрөг, дамжуулан зээлдүүлсэн зээл, зээлийн хүүгийн төлбөрт 1,334.5 сая төгрөг төлөхөөр, урсгал зардалд 204,1 сая төгрөг, хөрөнгө оруулалт, их засварт 7,041.0 сая төгрөг зарцуулахаар тус тус баталсан. МХХХТ түрээсийн орлого болон зээл зээлийн хүүгийн төлбөрт 2006 онд нийт 4,500.0 сая төгрөг төлж, 1,589.4 сая төгрөгийг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.
- 2.23 Дамжуулан зээлдүүлсэн зээл, зээлийн хүүгийн төлбөрийн талаар Сангийн яамтай тооцоо нийлсэн актнаас үзэхэд 2006 онд МХХХТ-өөс 7,969.2 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн төлбөрийн үлдэгдэлтэй байгаа тул энэ төлбөрийг хэрхэн барагдуулах талаар Сангийн яамнаас тодорхой шийдвэр гаргаж, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх нь зүйтэй байна.

ЗӨВЛӨМЖ:

Сангийн сайд Н.Баяртсайхан, “Мэдээлэл, холбооны сүлжээ” ХХК-ийн захирал Ч.Нарантунгалаг нарт:

- Дамжуулан зээлдүүлсэн зээл, зээлийн хүүгийн төлбөрийг барагдуулах талаар анхаарч ажиллах;

**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН
САНАЛ**

